

Техникийн нөхцөл:

НХА-ийн хашаанд нийт 16ш чиглэлийн /PIXED/, 1ш хөдөлгөөнт камерийг /PTZ/ гэрлийн багананд суурилуулна. Сүлжээний болон бичлэгийн төхөөрөмжийг конторын ҮЭХ-ийн даргын өрөөнд байрлуулна. Хяналтыг харуулын байранд оруулна.

Кабель суурилуулах ажил:

- Конторын барилгаас 4, 11, 14, 17, 18, 22, 26 багана хүртэл 12 судлын шилэн кабель, 220в-ын тэжээлийн кабелийг 60м гүнтэй, 30см өргөнтэй 1430м урт шуудуу ухаж суурилуулна
- Камерийн багана тус бүрт оруулалтын хайрцаг байрлуулж тэжээл болон сүлжээний төхөөрөмжүүдийг суурилуулна

Камер суурилуулах ажил:

- №4, 11, 14, 17, 18, 22, 26 багана дээр 12ш чиглэлийн камер /PIXED/ тавьж, Контор-Харуулын байран дээр 2ш чиглэлийн камер /PIXED/ тавина. Ачилтын задгай саравчинд 2ш чиглэлийн камер суурилуулна. Сүлжээний төхөөрөмж-шилэн кабелийн төгсгөлийн боксыг хайрцаганд байрлуулна.
- №9 багана дээр 1ш хөдөлгөөнт камер /PTZ/ суурилуулж сүлжээний төхөөрөмж-шилэн кабелийн төгсгөлийн боксыг хайрцаганд байрлуулна.
- Камерийг суурилуулахдаа бетонон багананд зориулалтын бүслүүр хийж бэхлэнэ

Бичлэгийн төхөөрөмж, сервер суурилуулах ажил:

- Бичлэг болон серверийн төхөөрөмжийг конторын ҮЭХ-ны даргын өрөөнд байгаа раканд суурилуулана
- Шилэн кабель болон тэжээлийн кабелийг ҮЭХ-ны даргын өрөөнд байгаа раканд холбоно
- Сүлжээний ракны тэжээлийг цахилгааны орлуултанд холбож 2квт-ын тасралтгүй тэжээлийн үүсгүүр UPS-ээр тэжээнэ

Хяналтын цэг:

- Харуулын байранд 32 сувгийн бичлэгийн төхөөрөмж, дэлгэцийн хамт тавьж
- Конторын барилгаас STP кабель татаж харуулын байрыг холбоно